



**МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn


2024. 03. 15 № 01/528

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасны дагуу “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, танилцуулгыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудастай.



Ч.ХҮРЭЛБААТАР

240195

Эдийн засаг, хөгжлийн яамны 2024
оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
01/28 дугаар албан бичгийн хавсралт

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”- ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

“Аймаг, нийслэл, хотыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэх, шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Арга зүй

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.7.1 дэх заалтыг баримтлан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн сангаар баталгаажуулж, хяналтад авсан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1-т заалтын дагуу тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан бөгөөд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан үндсэн 9 зорилгын хүрээнд зорилт, арга хэмжээг баталсан.

Мөн Архангай, Говь-сүмбэр, Завхан, Ховд аймгууд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоолоор “Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг батлахдаа хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсан байна.

3.1.Өмнөх оны гүйцэтгэл

Өмнөх 2022 оны байдлаар нийт 724 зорилт 3,101 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс 36.9 хувь нь үр дүнтэй, 36.8 хувь

нь тодорхой үр дүнд хүрсэн, 22.2 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 4.1 хувь нь үр дүнгүй үнэлэгдэж, дунджаар 76.5 хувийн үнэлгээтэй гарсан.

3.2. Тайлант оны гүйцэтгэл

“Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг батлахдаа дийлэнх аймгууд үндсэн 8 зорилгын хүрээнд зорилт, үйл ажиллагааг баталсан бөгөөд Булган, Дархан-Уул аймгууд 7 зорилгын хүрээнд, Өвөрхангай аймаг 4 зорилгын хүрээнд, Нийслэл 9 зорилгын хүрээнд арга хэмжээг баталсан байна. Тайлант онд нийт 724 зорилт 3,102 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс 95.4 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн бол 4.5 хувь нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, эрчимжүүлэх шаардлагатай үнэлэгдэж, дунджаар 86.1 үнэлгээтэй байна.

Аймаг тус бүрээр үнэлгээг гаргахад нийт дүнгээр 20 аймаг тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн бөгөөд Дархан-Уул аймаг 95.1 хувь, Хэнтий аймаг 92.8 хувиар үнэлэгдэж, 2023 оны хэрэгжилтээр хамгийн өндөр үнэлгээтэй гарлаа. Харин Завхан аймаг 63.7 хувийн хэрэгжилттэй гарсан бөгөөд удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Аймаг, нийслэлийн үнэлгээг нэгтгэн үндсэн зорилгоор нь тооцож үзэхэд “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгын хэрэгжилт 90.4 хувь, “Засаглал” зорилгын хэрэгжилт 90.0 хувь, “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгын хэрэгжилт 89.0 хувь, “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгын хэрэгжилт 88.1 хувь, “Хүний хөгжил” зорилгын хэрэгжилт 87.6 хувь, “Ногоон хөгжил” зорилгын хэрэгжилт 86.0 хувь, “Эдийн засаг”, “Дэд бүтцийн хөгжил” зорилгын хэрэгжилт 83.8 хувь, “Бүс, орон нутгийн хөгжил” зорилгын хэрэгжилт 79.6 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.

Булган аймаг “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгын хүрээнд арга хэмжээ төлөвлөөгүй бөгөөд “Дэд бүтцийн хөгжил” зорилгыг нэмэлтээр баталж хэрэгжилт нь 83.8 хувьтай, Дорнод аймаг “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгын хүрээнд арга хэмжээ төлөвлөөгүй, харин “Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого”-ыг баталж хэрэгжилт нь 100.0 хувийн хэрэгжилттэй, нийслэл “Улаанбаатар ба дагуул хот” зорилгыг нэмж батлан хэрэгжилт 86.5 хувьтай байна. Тус 3 зорилгын хүрээнд нийт 4,457.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зорилго тус бүрээс Говь-сүмбэр болон Дорнод аймгийн “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгын хэрэгжилт 100 хувийн үнэлгээтэй буюу үр дүнтэй хэрэгжсэн бол Дорнод аймгийн “Бүс, орон нутгийн хөгжил” зорилгын биелэлт 38.9 хувийн хэрэгжилттэй буюу үр дүнгүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй гэж үнэлэгдэж байна.

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийт 19¹ аймаг, нийслэлийн хэмжээнд 2.32 их наяд төгрөгийн төсвийг зарцуулахаар төсөвлөж, гүйцэтгэлээр 2.25 их наяд төгрөг буюу 96.9 хувийг зарцуулсан байна.

Зорилт, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь үзэхэд, улс, орон нутгийн төсвөөс гадна гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, гадаадын болон дотоод хөрөнгө оруулалт, Засгийн газрын тусгай сангууд болон хувийн хэвшлээс санхүүжилт хийсэн байна.

Хүснэгт 2. Аймаг, нийслэлийн санхүүжилтийн мэдээлэл

дд	Аймаг, нийслэл	Санхүүжилт /сая.төг/		Санхүүжилтийн эх үүсвэр
		Төлөвлөсөн	Гүйцэтгэл	
1	Архангай	13,536.0	23,971.3	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн даатгалын сан, Төсөл хөтөлбөр, Орон нутгийн хөгжлийн сан, Халамжийн сан.
2	Баян-Өлгий	27,128.6	36,549.6	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын нөөц хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сан, Гадаадын зээл тусламж.
3	Баянхонгор	120,307.5	27,094.6	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсөл хөтөлбөр, Орон нутгийн хөгжлийн сан, Гадаадын зээл тусламж, БХНСАХЗ, НҮБ-ын хүүхдийн сан.
4	Булган	50,325.3	31,075.9	Эх үүсвэрийг дурдаагүй.
5	Говь-Алтай	52,561.6	122,662.3	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсөл хөтөлбөр, Орон нутгийн хөгжлийн сан, Мал хамгаалах сан, Гадаадын зээл тусламж, Засаг даргын нөөц хөрөнгө, БХНСАХЗ, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан.
6	Говьсүмбэр	16,754.7	16,597.0	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, БХНСАХЗ, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан.
7	Дархан-Уул	450,792.8	289,488.2	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Орон нутгийн хөгжлийн сан, Гадаадын зээл тусламж.
8	Дорноговь	123,793.9	-	Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, Дэлхийн банк, бусад.
9	Дорнод	-	-	Эх үүсвэрийг дурдаагүй.
10	Дундговь	210,619.1	73,261.9	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Хоршоо хөгжүүлэх сан, Гадаадын зээл тусламж, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт.
11	Завхан	-	-	Эх үүсвэрийг дурдаагүй.
12	Нийслэл	16,283.5	-	Эх үүсвэрийг дурдаагүй.
13	Орхон	149,475.7	149,475.7	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Гадаадын хөрөнгө оруулалт, ШУТС, Төсөл хөтөлбөр, Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.
14	Өвөрхангай	1,094.4	99,263.0	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, ДНТ

¹ Тайлант онд Дорнод, Завхан аймгууд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг төлөвлөөгүй байна.

15	Өмнөговь	670,867.2	670,867.2	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
16	Сүхбаатар	53,040.8	97,609.7	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсөл хөтөлбөр, БХНСАХЗ.
17	Сэлэнгэ	330.6	330.6	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Зээл тусламж, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн даатгалын сан, Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсөв, Төсөл хөтөлбөр.
18	Төв	84,381.2	416,547.7	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, ДЗОУБТОХ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, БХНСАХЗ, Төсөл хөтөлбөр.
19	Увс	16,945.8	16,945.8	Хувийн хөрөнгө оруулалт, ХХС
20	Ховд	177,255.5	177,255.5	Эх үүсвэрийг дурдаагүй.
21	Хөвсгөл	4,754.2	4,754.2	БСУГ
22	Хэнтий	78,361.7	-	Эх үүсвэрийг дурдаагүй.
Дүн		2,318,610.1	2,253,750.2	

Зарим арга хэмжээний төсөв болон гүйцэтгэлийг ам.доллар болон еврогоор тооцож тайлан ирүүлснийг Монголбанкны 2023 оны 12 сарын 31-ний өдрийн ханшаар хөрвүүлэн тооцов. /1 ам.доллар-3,410.69 төгрөг, 1 евро-3,791.66 төгрөг/

3.3 Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилт

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.2.а дахь заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс тухайн аймаг, нийслэл, хотод хамаарахыг өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлсон байх;” гэж заасны дагуу нийслэл болон 13 /Архангай, Булган, Говь-Алтай, Говь-сүмбэр, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл/ аймаг 9 зорилгын хүрээнд шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсан боловч тайлант онд шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг ирүүлсэн аймаг байхгүй байна.

3.4 Тайлантай холбоотой гарсан асуудлууд:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-т “бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг эрэмбэ дараалал, үе шатаар тооцож тодорхойлох;” гэж заасны дагуу зорилго, зорилтын тухайн таван жилийн он тус бүрээр хүрэх үр дүн, санхүүжилт, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг багтаасан нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд аймгуудаас нарийвчилсан төлөвлөгөөг хавсарган ирүүлээгүй.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.2-т “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна”, 6.7.2.б дэх заалтад “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах;” гэж заасан боловч Архангай, Говь-сүмбэр, Дундговь, Завхан, Ховд аймгууд хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсан, бусад аймгууд батлаагүй байна. Аймгууд хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2023 онд ирүүлээгүй байна.

Мөн аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж нь тайлангийн үг, үсэг, утга найруулгын алдаанаас гадна санхүүжилтийн гүйцэтгэлийг сайтар нягтлах, хянах (“сая.төг” гэж тооцсон тохиолдолд бүх дүнг сая төгрөгөөр илэрхийлж цифр, тооны оронгийн алдаа гаргахгүй байх), зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг иж бүрэн тайлагнахаар журамд заасан хэдий ч тооны оронгийн нарийвчлалыг янз бүрээр оруулсан, санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг дутуу хагас хийсэн, танилцуулга хийж нэгтгэл гаргаагүй байна.

Тайланд үнэлгээ хийхдээ шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн тодорхойгүй буюу 2023 оны зорилтот түвшинг баталсан төлөвлөгөөг тайланд хавсаргаагүй боловч нийтлэг журмын 6.2.1 дэх заалтын “урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлал”-ыг баримталж үнэлгээг хийсэн байна.

Мөн тайланд 2022 болон 2023 оны хэрэгжилтийг бичсэн боловч хэт өндөр үнэлгээ тавьсан, арга хэмжээний хүрээнд тайлагнаагүй, хамааралгүй ажил бичсэн, хэт товч, ойлгомжгүй байдлаар бичсэн зэрэг нийтлэг алдаа дутагдлууд давтагдан гарч байна.

Нийслэл болон 13 аймаг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг баталсан боловч шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцож ирүүлээгүй.

Дорнод, Завхан, Дорноговь, Хэнтий болон Нийслэл санхүүжилтийн гүйцэтгэлийг гаргаагүй бөгөөд эх үүсвэрийн мэдээллийг ирүүлээгүй, Булган, Ховд, аймгууд санхүүжилтийн гүйцэтгэл гаргасан боловч эх үүсвэрийн мэдээллийг ирүүлээгүй байна.

Нийтлэг журмын 10.7.2-т “бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг Засаг даргын зөвлөл, агентлагийн даргын хурлаар хэлэлцүүлсний дагуу цахим санд оруулан баталгаажуулж, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэх;” гэсэн заалтыг баримтлах, цаашид 1 дүгээр хавсралтад заасан хугацаа /жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор/-нд тогтмол ирүүлж байхаар тусгасан боловч Баянхонгор, Булган, Говь-сүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгууд хурлын тэмдэглэлийг хавсаргаагүй системд баталгаажуулсан байна.


Дөрөв. Дүгнэлт

“Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2023 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 86.1 хувийн блттэй гарсан бөгөөд нийт 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд 95.4 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн бол 4.5 хувь нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн.

Аймаг, нийслэлийн дундаж үнэлгээг гаргахад Дорнод 75.8 хувь, Сүхбаатар 76.7 хувь, Архангай 77.2 хувь, Өмнөговь 82.3 хувь, Говь-Алтай 83.9 хувь, Хөвсгөл 86.2 хувь, Дорноговь 86.7 хувь, Дундговь 87.1 хувь, Өвөрхангай 87.9 хувь, Баянхонгор 88.1 хувь, Булган 88.7 хувь, Ховд 88.9 хувь, Говь-сүмбэр 89.6 хувь, Увс 89.8 хувь, Орхон 89.8 хувь, Баян-Өлгий 90.3 хувь, Төв 90.8 хувь, Сэлэнгэ 91.6 хувь,

Хэнтий 92.8 хувь, Дархан-Уул 95.1 хувь, Нийслэл 90.5 хувийн хэрэгжилттэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.

График 1. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны жилийн эцсийн үнэлгээ, аймаг, нийслэлээр



Харин Завхан аймаг 63.7 хувийн хэрэгжилттэй үнэлэгдэж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-т “бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг эрэмбэ дараалал, үе шатаар тооцож тодорхойлох;” гэж заасны дагуу зорилго, зорилтын тухайн таван жилийн он тус бүрээр хүрэх үр дүн, санхүүжилт, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг багтаасан нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, төлөвлөгөөг тайлангийн хамт Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж байх;
- Тайлангийн үг, үсэг, утга найруулгыг хянах, санхүүжилтийн гүйцэтгэлийг тайлагнах, эх үүсвэрийг дурдаж байх, цифр, тооны оронгийн нарийвчлалын алдаа гаргахгүй байх;
- “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.1.3 дахь “хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;” зарчмыг баримтлан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хамаарах тооцоо, судалгааг хавсарган ирүүлж байх.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ